



Монголын Хүүхдийн  
Төлөө Үндэсний Хороо



Нэгдсэн Үндэстний  
Байгууллагын  
Хүүхдийн Сан



Монголын Тахир Дутуу  
Иргэдийн Холбоо

# ТАХИР ДУТУУ ХҮҮХДИЙН ХЭРЭГЦЭЭ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА

/АЛБАН ХЭРЭГЦЭЭНД/



Улаанбаатар хот  
2001 он

## ОРШИЛ


Монгол Улсын Засгийн Газар, НҮБ-ын Хүүхдийн сангийн 1997-2001 оны хамтын ажиллагааны дагуу Хүүхдийн төлөө Үндэсний хороо “Тахир дутуу хүүхдийг олон нийтийн хүчинд тулгуурлан нөхөн сэргээх” төслийг Улаанбаатар хотод төвлөрүүлэн хэрэгжүүлж байгаа билээ. Энэхүү төслийн үндсэн зорилго нь тахир дутуу, эмгэг согогтой хүүхдийн нийгмийн энгийн орчинд адил тэгш эрхтэйгээр сурч хөгжих боломжийг бүрдүүлэх, тэдний бие даан ажиллаж амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд чиглэгддэг юм.

Төслийг хэрэгжүүлэх явцад Тахир дутуу хүүхдийн дийлэнх нь бие бялдрын болон оюун санааны эмгэгээсээ шалтгаалан айх ичих, бусад хүүхдийн зүгээс дарамт учруулах зэрэг байнгын сэтгэл санааны бэрхшээлтэй тулгарч, нийгмийн энгийн харилцаанд орох нөхцөл боломж хязгаарлагдаж байдаг нь ажиглагдсан юм. Нөгөө талаар эдгээр хүүхдийн онцлогийг харгалзсан тусгай үйлчилгээний арга хэлбэр ч үгүйлэгдэж байна. Иймд тахир дутуу хүүхдийн бие эрхтэний болон оюуны үйл ажиллагааг нөхөн сэргээхэд гэр бүл, олон нийтийн ойлголт, оролцоог нэмэгдүүлэх, тэдэнд зориулсан мэргэжлийн үйлчилгээг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааны хэрэгцээ, шаардлагыг бодитойгоор тогтоох үүднээс Тахир дутуу хүүхдийн хэрэгцээ тодорхойлох судалгааг нийслэлийн 9 дүүргийн нийт тахир дутуу эмгэг согогтой хүүхдийг хамруулан өөрсдийнх нь болон эцэг эхийнх нь оролцоотойгоор явуулж, дүнг Та бүхэнд хүргүүлж байна.

Судалгааг Хүүхдийн төлөө Үндэсний хороо, Монголын Тахир дутуу иргэдийн холбоо хамтран Улсын Статистикийн газар болон нийслэлийн Эрүүл мэндийн газрын эмч, мэрэгжилтнүүдийн туслалцаатайгаар явуулсныг илэрхийлэхийн ялдамд тахир дутуу хүүхэдтэй айл өрх бүрээр орж, судалгааны асуулгыг аль болох үнэн бодитойгоор явуулахад хүчин чармайлт гарган ажилласан нийслэлийн нийт өрхийн эмч нарт талархал илэрхийлье.

Уг судалгааны дүн болон арга зүй нь энэ чиглэлээр ажиллаж байгаа байгууллага, хүмүүсийн ажилд бодитой тус нэмэр болно гэдэгт найдаж байна.

“Гэр бүл, хүүхдийн сайн сайхны төлөө хөтөлбөр”-ийн үндэсний зохицуулагч,  
Хүүхдийн төлөө Үндэсний хорооны дэд дарга Б.УРАНБИЛЭГ



E-mail: ncc\_uranbileg@magicnet.mn  
329209, 323737

## **СУДАЛГААНЫ ЗОРИЛГО**

Нийслэлийн 9 дүүргийн тахир дутуу хүүхдийн нийгмийн хэрэгцээг тодорхойлж, эдгээр хүүхэдтэй ажиллах бодит үндэслэлийг тогтоох

### **НЭГ. СУДЛАХ ЗҮЙЛ**

- Тахир дутуу хүүхдийн тоог нас, хүйсээр тодорхойлох.
- Тахир дутуу хүүхдийн амьдарч байгаа нөхцөл, орчинг судлах
- Тэдгээрийн тахир дутуугийн хэлбэрийг тодорхойлох
- Тахир дутуу хүүхдүүдийн нэн шаардлагатай хэрэгцээг судлах явдал юм.

#### **Судалгааны хамрах хүрээ:**

Улаанбаатар хотод оршин суугаа 0-18 насны тахир дутуу хүүхэдтэй өрхүүдийг судалгаанд хамруулав.

#### **Судалгааны нэгж:**

0-18 насны тахир дутуу хүүхэдтэй өрх судалгааны нэгж болно.

#### **Судалгааны хугацаа:**

Энэ судалгаа нь нэг удаагийн судалгаа бөгөөд судалгааны мэдээллийг 2000 оны 11 сарын байдлаар цуглуулав.

**Судалгааны асуулгын хуудасны загвар:**

Энэ удаагийн судалгааны асуулга, түүнийг нөхөх зааврыг боловсруулахын тулд олон улсын статистикийн аргачлал, заавар бусад улс, орны ижил төстэй материалыг судалж, Монгол улсын өнөөгийн онцлог, нөхцөл байдалтай уялдуулан боловсруулав. Судалгааны асуулгын хуудас, түүнийг нөхөх зааврыг хавсаргав. Энэ удаагийн судалгаанд асуулгын 3 төрлийн маягыг заавар, аргачлалын хамт боловсруулж, хэрэглэв.

**Судалгааны асуулгын хуудас:**

Судалгааны асуулгын хуудас нь дараахи 4 бүлгээс бүрдэнэ. Үүнд:

- А. Хаягийн хэсэг
- Б. Өрхийн ам бүл, гишүүдийн боловсрол, ажил эрхлэлт
- В. Тахир дутуу хүүхдийн талаар
- Г. Тахир дутуу хүүхдийн хэрэгцээ

**Судалгааны асуулгуудын агуулгын талаар:**

**А. Хаягийн хэсэгт:** Өрхийн хаяг, байршил, ам бүлийн тоо, 18 хүртэлх насны гишүүд, тахир дутуу хүүхдийн тоо, өрхийн сууцны байдал, өмчийн хэлбэр, ундны усны болон ариун цэврийн байгууламжийн хангамж, өрхийн орлогын хэмжээ;

**Б. Өрхийн ам бүл, гишүүдийн боловсрол, ажил эрхлэлт:** Өрхийн гишүүдийн хүйс, нас, тахир дутуу хүүхдүүд эх, эцэгтэйгээ хамт амьдардаг эсэх, гишүүдийн боловсрол, цэцэрлэг, сургуульд хамрагдалт, 15-аас дээш насны гишүүдийн ажил эрхлэлтийн байдал;

**В. Тахир дутуу хүүхдийн талаар:** Энэ бүлэгт тахир дутуу хүүхдийн төрсөн он, нас, түүний тахир дутуугийн төрөл, хэлбэр мөн тахир дутуу болсон шалтгаан, эзэмшсэн мэргэжил;

**Г. Тахир дутуу хүүхдийн хэрэгцээ:** Энэ бүлэгт тахир дутуу хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, хамгаалал, ахуйн болон онцгой шаардлагатай хэрэгцээг мөн тэдний авьяас, сонирхолын талаархи асуулгыг тус тус тусгасан.

Судалгааны асуулгын хуудас, түүнийг нөхөх зааврыг Хүүхдийн төлөө Үндэсний Хорооны зөвлөмжийн дагуу Үндэсний Статистикийн Газар боловсруулав.

**Судалгаа явуулсан талаар:**

Мэдээлэл цуглуулах шатны ажлыг Хүүхдийн төлөө Үндэсний Хороо, Тахир Дутуу Иргэдийн Холбооноос удирдан зохион байгуулж, нийслэлийн дүүргийн хүний их эмч нарыг ярилцлага авагчаар ажиллуулсан. Ярилцлага авагч нарт зориулсан 1 хоногийн сургалтыг батлагдсан хөтөлбөрөөр холбогдох заавар, журмын дагуу явуулж, дадлагын ажлыг хийв. Сургалтанд оролцогч нарт судалгаанд хамрагдсан өрхийн гишүүдтэй элэгсэг харьцаж, зарим эмзэг асуултыг болгоомжтой асуух нөхцлийг хэрхэн сонгож, бүрдүүлэх мөн асуулганд бүрэн хангалттай хариулт авах зорилгоор асуулгыг судалгааны маягтанд бичсэнээр бус тэр асуултыг зохистой хэлбэрт хувиргаж өөрөөр асуух хувилбарыг олох, хариултыг асуулгын хуудсанд гаргацтай, нямбай нөхөн бичих, Монгол улсын статистикийн хуулийн дагуу судалгааны мэдээллийн нууцыг хадгалахыг онцгойлон анхааруулав.

**Мэдээллийн боловсруулалт:**

Мэдээллийг асуулгын хуудсаар 1435 өрхөөс цуглуулж, уг судалгааны мэдээллийг компьютерийн боловсруулалтанд бэлтгэх, мэдээллийг хянах, шалгах, засварлах болон мэдээллийг боловсруулж үр дүнгийн хүснэгт гаргах үе шатны ажлын технологийн дагуу 3 төрлийн программыг боловсруулж, туршсаны үндсэн дээр судалгааны цуглуулсан мэдээллийг боловсруулав. Судалгааны үр дүнгийн хүснэгт гарган авах программд статистик судалгааны SPSS программ хангамжийг ашигласан болно. Боловсруулалтанд бэлтгэж байгаа мэдээллийн үнэн зөвийг давхар шалгахын тулд технологийн дагуу давхар шивэлтийг хийсэн. Боловсруулалт хийгдсэн үр дүнгийн хүснэгтүүдийн үзүүлэлт бүрийн хоорондын логик уялдаа болон мэдээллийн үндсэн үзүүлэлтүүд дээр статистикийн шинжилгээний аргаар хяналтыг явуулсаны үндсэн дээр мэдээлэл дээр шаардлагатай засвар, боловсруулалтуудыг хийж, мэдээллийн санг байгуулав. Мэдээллийг хянах, засварлах, шалгах, компьютерт бэлтгэн оруулах ажлыг тусгай боловсруулсан программуудын дагуу нарийн хуваарь, хяналттайгаар гүйцэтгэв.

**Мэдээллийн бүрэн байдал:**


Энэ удаагийн судалгаанд 0-18 насны тахир дутуу хүүхэдтэй 1435 өрх хамрагдсанаас мэдээллийг 1432 өрхөөс бүрэн авч, судалгаанд хамрагдалтын түвшин 99.8 хувь байна. Судлагдсан өрхүүдэд 0-18 насны нийт 1497 хүүхэд бүртгэгдсэнээс 1492 хүүхэд асуулганд бүрэн хамрагдаж, хамрагдалтын түвшин 99.7 хувь байгаа нь судалгааны ерөнхий хамрагдалтын түвшин өндөр байгааг харуулж байна.

Асуулгын хуудсанд өгөгдсөн зарим үзүүлэлтийн байдлаар судалгааны хамрагдалтын байдлыг авч үзэхэд ярилцлаганд хамрагдсан өрхийн сууцны байдлын талаархи асуулгыг бүрэн, харин ярилцлаганд хамрагдсан өрхийн гишүүдийн 0.1 хувь нь өрхийн гишүүдийн боловсролын талаархи асуулгыг, хүүхдийн цэцэрлэг, сургуульд хамрагдалтын талаархи мэдээллийн 6.4 хувь, нийгмийн халамжийн үйлчилгээний талаархи асуулгын мэдээллийн 6.9 хувь, ахуйн болон онцгой хэрэглээний талаархи асуулгын мэдээллийн 13.2 хувь нь бүрэн бус буюу алдаатай мэдээлэл байв. Гэхдээ энэхүү асуулгын дагуух мэдээллийг цаашид судалгаа, шинжилгээнд бүрэн ашиглаж болно. Арван найм хүртэлх насны тахир дутуу хүүхдүүдийн авьяас, сонирхлын талаархи асуулгын бүрдэлт хангалтгүй байгааг судлаач, хэрэглэгч нарын анхааралд хүргэж, цаашид үнэлэлт, дүгнэлт хийхдээ болгоомжтой хандахыг анхааруулж байна.

## ХОЁР. СУДАЛГААНЫ ДҮН

Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын дүнгээр Монгол улсын хүн амын 32.5 хувь буюу 760 мянган хүн нийслэл Улаанбаатар хотод амьдарч байна. Нийслэл Улаанбаатар хотын хүн ам нь Хан-Уул, Багануур, Баянзүрх, Налайх, Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй, Багахангай, Сонгинохайрхан дүүрэгт харьяалагддаг бөгөөд хүн амын 20.3 хувь нь Сонгино хайрхан дүүрэгт, 19.4 хувь нь Баянзүрх, 18.1 хувь нь Баянгол, 13.7 хувь нь Чингэлтэй дүүрэгт, 12.1 хувь нь Сүхбаатар дүүрэгт, 6.4 хувь нь Багануур, Налайх, Багахангай дүүрэгт тус тус амьдардаг байна.

Зураг 1.




Улаанбаатар хотын хүн амын 42.7 хувь нь 0-19 насны хүүхэд, өсвөр үеийнхэн, 30 шахам хувь нь 20-34 насны залуучууд байна.

'Хүүхэд, хөгжил-2000' судалгааны дүнгээр Улаанбаатар хотын 3-5 настай хүүхдүүдийн 41.2 хувь нь сургуулийн өмнөх боловсрол олгох хөтөлбөрт хамрагдсан байна. Албан ёсны статистикийн мэдээгээр тусгай сургуульд 36085\_ хүүхэд суралцаж байна.

**II.1 Судалгаанд хамрагдсан тахир дутуу хүүхэдтэй өрхийн хүн ам зүйн байдал:**

Манай судалгаанд тахир дутуу, 0-18 насны 1492 хүүхэд хамрагдсан. Судалгаанд хамрагдсан тахир дутуу хүүхдүүдийн 17.5 хувь нь 0-4 насны, 5 болон 7-8 настай хүүхдүүд тус бүр 9.8 хувийг; 49.5 хувийг 9-15 насны хүүхдүүд, 12.7 хувийг 16-18 насны өсвөр үеийнхэн эзэлж байна. Судалгаанд хамрагдсан тахир дутуу хүүхдүүдийн дунд 1 хүртэлх насны 4 эрэгтэй хүүхэд, 18 настай эрэгтэй нэг, эмэгтэй хоёр хүүхэд байна. (Хүснэгт 5).

Зураг 2.




Судалгаанд хамрагдсан тахир дутуу хүүхдүүдийн 54.4 хувь нь эрэгтэй хүүхэд байна.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 19.2 хувь нь Сонгино хайрхан дүүрэгт, 16-17.3 хувь нь Баянгол, Баянзүрх, 11.8-13 хувь нь Хан-Уул, Чингэлтэй дүүргээс хамрагдсан байна. (Хүснэгт 4).

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийг өрхийн ам бүлийн байдлаар авч үзвэл тахир дутуу хүүхдүүдийн хоёрны нэг нь 4-5 ам бүлтэй өрхөд, бараг дөрөвний нэг нь 6-7 ам бүлтэй өрхөд, 10 шахам хувь нь 8-аас дээш ам бүлтэй өрхөд амьдарч байна.


Зураг 3.

Судалгаанд хамрагдсан тахир дутуу хүүхдүүд, өрхийн тоогоор



Зураг 4.

Судалгаанд хамрагдсан тахир дутуу хүүхдүүд, өрхийн ам бүлийн тоогоор





Судлагдсан өрхийн 92.5 хувь нь тахир дутуу нэг хүүхэдтэй байхад 6 хувь нь тахир дутуу 2 хүүхэдтэй, 1 орчим хувь нь ийм 3 хүүхэдтэй өрх байна.

Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын дүнгээр нийслэлийн боловсролгүй хүн амын 55.8 хувь нь 7-9 насны, 33.5 хувь нь 10-14 насны, 1.7 хувь нь 15-19 насны хүүхэд, залуучууд байна.

7-9 насны боловсролгүй хүн амын 20.7 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт, 19.2 хувь нь Баянзүрх, 17.3 хувь нь Баянгол дүүрэгт, 13.9 хувь нь Чингэлтэй дүүрэгт 9.4 хувь нь Хан-Уул дүүрэгт байна. Мөн 10-14 насны бага боловсролтой хүн амын 40 хувь нь Баянзүрх, Сонгино хайрхан дүүрэгт, 18.6 хувь нь Баянгол дүүрэгт, 13.4 хувь нь Чингэлтэй дүүрэгт, 12.2 хувь нь Сүхбаатар дүүрэгт 8.9 хувь нь Хан-Уул дүүрэгт байна.

Судалгаанд хамрагдсан тахир дутуу хүүхдүүдийн 21.8 хувь нь дээд боловсролтой тэргүүлэгчтэй өрхөд, 36.1 хувь нь бүрэн дунд боловсролтой тэргүүлэгчтэй, 34.7 хувь нь бүрэн бус дунд боловсролтой тэргүүлэгчтэй, 7.4 хувь нь боловсролгүй ба бага боловсролтой тэргүүлэгчтэй өрхөд тус тус хамаарч байна.

## **II.2 Тахир дутуу хүүхдүүдийн амьдарч байгаа сууцны байдал:**


Манай судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 72.6 хувь нь байшин сууцанд, 26.5 хувь нь гэрт амьдарч байна.

Тэдний сууцыг өмчийн хэлбэрээр авч үзвэл, энэ хүүхдүүдийн 22.4 хувь нь улсын сууц, 76.1 хувь нь хувийн сууц, 0.9 хувь нь бусдын сууцыг хөлсөлж эзэмшиж байна.

Тахир дутуу хүүхдүүдийн амьдарч буй сууцны байдлыг дүүргээр нь харьцуулж үзвэл тахир дутуу хүүхдүүдийн 51.9-91.7 хувь нь байшин сууцанд амьдарч байгаагийн дотор Баянгол дүүргийн тахир дутуу хүүхдүүдийн 90 гаруй хувь нь байшин сууцанд амьдарч байгаа нь дүүргүүдийн дунд байшин сууцны хангамж өндөртэй нь байна.

Харин байшин сууцны хангамж хамгийн бага нь Баянзүрх дүүрэгт 51.9 хувь байна. Түүнчлэн Чингэлтэй, Хан-Уул, Сүхбаатар, Багануур, Баянзүрх дүүргүүдийн тахир дутуу хүүхдүүдийн 69.3-88.6 хувь нь Багахангай дүүргийн ийм хүүхдийн 37.5 хувь нь хувийн эзэмшлийн сууцанд амьдарч байна. (Хүснэгт 7).

Зураг 5.




Тахир дутуу хүүхдүүдийн амьдарч байгаа сууцны хэлбэрийг тэдний тахир дутуугийн хэлбэрээр нь ангилж үзэхэд сонсгол, хэл ярианы дутагдалтай хүүхдүүдийн 77 хувь, сэтгэцийн өөрчлөлттэй хүүхдүүдийн 72.2 хувь, хөдөлгөөний дутагдалтай хүүхдүүдийн 71 хувь, оюуны хомсдолтой хүүхдүүдийн 68.9 хувь нь байшин сууцанд амьдарч байна.

### II.3 Өрхийн ундны усны хангамж

Тахир дутуу хүүхдүүдийн 44.9 хувь нь төвлөрсөн усан хангамжтай сууцанд амьдарч, 52.7 хувь нь ундны усаа худгаас, 1.5 хувь нь тээврийн уснаас авч хэрэглэдэг байна. Баянгол дүүргийн тахир дутуу хүүхдүүдтэй өрхүүдийн төвлөрсөн усан хангамжинд хамрагдалтын байдал 89.6 хувь байгаа нь дүүргүүдийн дунд хангамжийн түвшин хамгийн сайтай нь байна. Хангамжийн түвшин хамгийн багатай нь Чингэлтэй дүүрэг буюу 15.9 хувь байна. Чингэлтэй дүүргийн тахир дутуу хүүхдүүдийн 83.5 хувь нь ундны болон хэрэглээний усаа худгаас хангадаг байна. Өрхийн эзэмшиж байгаа сууцны төрлөөс хамаарч дээрхи хүүхдүүдийн ашиглаж байгаа ариун цэврийн байгууламжийн төрөл өөр өөр байна.


Зураг 6.



Гэрт амьдардаг хүүхдүүд ариун цэврийн ердийн байгууламж хэрэглэнэ. Хэдийгээр хүүхдүүдийн дийлэнхи нь байшин сууцанд амьдардаг ч сууц дотроо ариун цэврийн байгууламжтай өрх нийт өрхийн 44.7 хувийг, сууцны гадна байгууламжтай өрх 51.7 хувийг тус тус эзэлж байна. Баянзүрх, Сүхбаатар дүүргийн тахир дутуу 3 хүүхэд тутмын нэг нь, Хан-Уул, Сонгино хайрхан дүүргүүдийн тахир дутуу бараг 2 хүүхэд тутмын нэг нь, Чингэлтэй дүүргийн тахир дутуу хүүхдүүдийн дөнгөж 14.9 хувь нь сууц дотроо ариун цэврийн байгууламжтай байна. (Хүснэгт 8).

Хөдөлгөөний болон оюуны хомсдолтой мөн сонсгол, хэл ярианы согогтой хүүхдүүдийн тус бүр 55 хувь нь, сууцны гадна байрлалтай ариун цэврийн байгууламж ашиглаж байна.

Зураг 7.



**II.4. Тахир дутуу хүүхэдтэй өрхийн амьдралын түвшин, өрхийн нэг гишүүнд ногдох сарын дундаж орлогын хуваарилалтаар:**


Судалгаанд хамрагдсан тахир дутуу хүүхдүүдтэй өрхийн амьдралын түвшинг өрхийн нэг гишүүнд ногдох сарын дундаж орлогын түвшингээр хуваарилан үзэхэд нийт хүүхдүүдийн 4.9 хувь нь орлогын эх үүсвэргүй, 28.5 хувь нь өрхийн нэг гишүүнд ногдох сарын дундаж орлогын хэмжээ 5000 хүртэл төгрөг, 33 хувь нь 5000-10000 төгрөгний, 26 хувь нь 11-20 мянган төгрөг, 5.5 хувь нь 21-30 мянган төгрөг, 1.7 хувь буюу 26 хүүхэд 30 мянгаас дээш төгрөг бүхий өрхөд амьдарч байна.

Налайх, Чингэлтэй, Сонгинохайрхан, Хан-Уул, Баянзүрх дүүргийн тахир дутуу хүүхдүүдийн 69.8-83.1 хувь нь амьжиргааны эх үүсвэр орлогогүй эсвэл өрхийн нэг гишүүнд сард дунджаар 10000 төгрөг хүртэлх орлого ногдох өрхөд амьдарч байна. Харин Баянгол, Багахангай, Багануур дүүргийн хувьд хүүхдүүдийн 30-аас дээш хувь нь өрхийн нэг гишүүнд сард дунджаар 11-20 мянган төгрөгийн орлого ногдох өрхөд амьдарч байна.

Түүнчлэн өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшингээр өрхийн амьжиргааны түвшинг харьцуулан үзэхэд дээд боловсролтой тэргүүлэгчтэй өрхийн 39.7 хувь нь, бүрэн дунд болон бүрэн бус дунд боловсролтой тэргүүлэгчтэй өрхийн 68.1-76.6 хувь, бага боловсролтой эсвэл боловсролгүй тэргүүлэгчтэй өрхийн 87.6-92.2 хувь нь өрхийн нэг гишүүнд 10000 хүртэлх төгрөг ногдох орлоготой өрхүүд байна.

Харин дээд боловсролтой тэргүүлэгчтэй өрхийн 41 хувь нь, бүрэн бус дунд ба бүрэн дунд боловсролтой тэргүүлэгчтэй өрхийн 20.7-26.2 хувь нь өрхийн нэг гишүүнд сард 20000 хүртэлх төгрөг ногдох орлоготой өрхүүд байна (Хүснэгт 9).

Зураг 8.



Хүн амын амьдралын түвшинд нөлөөлөх нэгэн гол зүйл бол өрхийн гишүүдийн ажил эрхлэлт байдал билээ. Манай судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 70 хувь нь ажил эрхэлдэг хүнтэй өрхөд амьдарч байна.

Тахир дутуу хүүхдүүдийн амьдарч байгаа өрхийн гишүүдийн ажил эрхэлж байгаа хүний тоогоор нь бүлэглэн үзэхэд, энэ хүүхдүүдийн 52.3 хувь нь өрхийн нэг гишүүн нь ажил эрхэлдэг, 38.6 хувь нь ажил эрхэлдэг 2 хүнтэй өрх байгаа ба судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 30 хувь буюу 448 өрхийн гишүүдийн нэг нь ч ажил эрхэлдэггүй өрхөд хамаарч байгаа нь хүүхдүүдийн амьдрах орчин эрс ялгаатай байгааг харуулж байна. Ялангуяа Багахангай, Налайх, Сүхбаатар дүүргийн тахир дутуу хүүхдүүдийн 52.1-100 хувь нь ажил эрхэлдэг нэг ч хүнгүй өрхөд байдаг байна. (Хүснэгт 11).

Тахир дутуу хүүхдүүдийн 84.2 хувь нь эцэг, эхийн асрамжинд, 0.3 хувь нь ах, эгчийнхээ асрамжинд, 2.6 хувь нь хамаатан, төрөл садангийнхаа асрамжинд 12.6 хувь нь бусдын асрамжинд хамт амьдардаг байна.

Хан-Уул, Баянзүрх, Налайх дүүргийн тахир дутуу хүүхдүүдийн 11.3-16.5 хувь нь бусдын асрамжинд амьдарч байгаа нь дүүргүүдийн дундаас хамгийн олон нь байна.

Судалгаанд хамрагдсан тахир дутуу хүүхдүүдээс нэг нас хүрээгүй 2 хүүхэд, 2 настай 68 хүүхдийн 33.8 хувь, 4 хүртэлх насны 42 хүүхдийн 23.8 хувь, харин 1, 3 мөн 5-8 насны хүүхдүүдийн 15.5-17.2 хувь нь эцэг, эх, төрсөн ах, эгчийн асрамжны гадна амьдардаг байна.

Ялангуяа хөдөлгөөн, оюуны хомсдол, харааны согогтой хүүхдүүдийн 12-15.4 хувь нь эцэг эх, төрсөн ах, эгчээс тусдаа амьдардаг байна. (Хүснэгт 10).


## II.5. Боловсролын байдал:

*Тахир дутуу хүүхдүүдийн цэцэрлэг, сургуульд хамрагдалтын байдал*

**Цэцэрлэг:** Судалгаанд хамрагдсан 5 хүүхэд тутмын нэг нь буюу 20.2 хувь нь цэцэрлэгийн насны хүүхдүүд байна. Энэ хүүхдүүдийн дөнгөж 35.1 хувь буюу 106 хүүхэд цэцэрлэгт хамрагдсан байна. Хан-Уул дүүргийн цэцэрлэгийн насны тахир дутуу хүүхдүүдийн тал хувь нь, Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан дүүргийн ийм хүүхдүүдийн 39.3 хувь нь цэцэрлэгт хамрагдсан байна. Цэцэрлэгт хамрагдсан хүүхдүүдийн 26.4 хувь нь тусгай цэцэрлэгт хамрагдсан байна. Цэцэрлэгт хамрагдсан хүүхдүүдийг насны байдлаар нь авч үзэхэд 4 настай хүүхдүүдийн 40 гаруй хувь, 4 болон 6-7 насны бараг гурван хүүхдийн нэг нь цэцэрлэгт хамрагджээ.

Цэцэрлэгийн насны, харааны согогтой хүүхдүүдийн 51.3 хувь, сэтгэцийн болон сонсгол, хэл ярианы гажигтай 3 хүүхдийн нэг нь, хөдөлгөөний болон оюуны хомсдолтой бараг 5 хүүхэд тутмын нэг нь цэцэрлэгт хамрагдсаны дотроос сонсгол, хэл, ярианы согогтой хүүхдүүдийн тал шахам хувь нь тусгай цэцэрлэгт хамрагдсан байна. (Хүснэгт 12). Манай судалгаанд хамрагдсан цэцэрлэгийн насны цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдүүдийн дийлэнхи буюу 72.8 хувь нь өвчтэй учраас, 15.8 хувь нь амьдралын боломжгүйгээс, 9 хүүхэд сонирхолгүйгээс, 5-6 насны хоёр хүүхэд бусдаас ичиж, зовсноос шалтгаалж цэцэрлэгт хамрагдаагүй байна. Амьдралын боломжгүйгээс цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдүүдийн 44 хувь буюу 11 хүүхэд Баянгол дүүрэгт байна. Сонгинохайрхан дүүргийн харьяат 6 настай нэг хүүхэд техник, тоног төхөөрөмж дутагдалтайгаас цэцэрлэгт хамрагдаагүй байна. (Хүснэгт 14).

• Зураг 9.



*Ерөнхий боловсролын сургуульд хамрагдалт:*

Судалгаанд ерөнхий боловсрол олгох насны тахир дутуу 1016 хүүхэд хамрагдсаны 48.8 хувь ерөнхий боловсрол олгох сургуульд хамрагдсан байна. Энэ хүүхдүүдийн 62.9 хувь буюу 312 хүүхэд ердийн сургуульд, 37.1 хувь буюу 184 хүүхэд тусгай сургуульд хамрагдаж, 106 хүүхэд сургууль завсарджээ. Сургуульд хамрагдсан оюуны хомсдолтой хүүхдүүдийн 56.9 хувь, сонсгол, хэл ярианы гажигтай хүүхдүүдийн 60.5 хувь нь тусгай сургуульд хамрагдсан нь тахир дутуугийн бусад төрлүүдээс хамгийн өндөр хамралттай нь байна. Сургууль завсардсан хүүхдүүдийн 65.1 хувь нь хөдөлгөөний болон оюуны хомсдолтой хүүхдүүд, 21.7 хувь нь сонсгол, хэл ярианы гажигтай, 10 гаруй хувь нь сэтгэцийн гажигтай хүүхдүүд байна. Сургууль завсардсан хүүхдүүдийн 75.5 хувь нь Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх, Сүхбаатар дүүргийн тахир дутуу хүүхдүүд байна.

Сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийн дийлэнхи нь Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул, Баянзүрх дүүрэгт байна. (Хүснэгт 15).

Сургуульд хамрагдсан хүүхдүүдийн 52.4 хувь нь эрэгтэй хүүхдүүд байна. Хүүхдүүдийн сургуульд хамрагдалтын байдлыг тэдний насны бүлгээр авч үзвэл 75.8 хувь нь 9-15 насны, 7.7 хувь нь 8 настай хүүхдүүд, 16.5 хувь нь 16-18 насны өсвөр үеийнхэн байна. (Хүснэгт 16).

Судалгаанд хамрагдсан 12-18 насны тахир дутуу хүүхдүүдийн 10.8 хувь нь бүрэн дунд, 4.2 хувь нь бүрэн бус дунд, 32 хувь нь бага боловсрол эзэмшиж, 53 хувь нь боловсрол эзэмшээгүй байна. Энэ насны хүүхдүүдийн дунд харааны гажигтай хүүхдүүдийн 22.2 хувь, сонсгол, хэл ярианы гажигтай хүүхдүүдийн 13.6 хувь нь бүрэн дунд боловсрол мөн хараа, сонсгол, хэл ярианы гажигтай хүүхдүүдийн тус бүр 40 орчим хувь нь бага боловсрол эзэмшсэн нь тахир дутуугийн бусад төрлүүдтэй харьцуулахад хамгийн их байна. (Хүснэгт 17).

Сургуульд хамрагдаагүй 414 хүүхдийн 69.1 хувь нь хөдөлгөөний болон оюуны хомсдолтой, 19.3 хувь нь сонсгол, хэл ярианы гажигтай хүүхдүүд байгаагийн зэрэгцээ энэ хүүхдүүдийн 57.7 хувь буюу 239 хүүхэд өвчтэй, 7.7 хувь буюу 32 хүүхэд амьдралын боломжгүйгээс шалтгаалж сургуульд хамрагдаагүй байна. (Хүснэгт 18).


Сургуульд хамрагдаагүй дээрхи хүүхдүүдийн 3.8 хувь нь их дээд сургуульд, 5.2 хувь нь тусгай мэргэжлийн боловсрол олгох сургуульд, 32.8 хувь нь ердийн сургуульд, 20 хувь нь тусгай хэрэгцээт боловсрол олгох, 15.9 хувь нь танхимын бус сургалтад, 11.3 хувь нь мэргэжил олгох дамжаанд тус тус суралцах хүсэл, сонирхолтой гэж судалгааны асуулганд хариулсан байна.

Оюуны хомсдолтой дээрхи хүүхдүүдийн 22.9 хувь нь танхимын бус сургалтаар мөн оюуны хомсдол, хэл ярианы гажигтай хүүхдүүдийн тус бүр 30.6 хувь нь тусгай хэрэгцээт боловсрол эзэмших хүсэлтэй байхад сэтгэцийн болон хөдөлгөөний хомсдол, харааны гажигтай хүүхдүүдийн 36.7-48 хувь нь ердийн сургуульд суралцах хүсэлтэй байна. (Хүснэгт 19).

**II.6 Тахир дутуу хүүхдэд үзүүлж байгаа асрамж, хандлага:**

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 78.2 хувь нь гэр бүлийн зүгээс сайн хандаж, асрамжилдаг гэж хариулсан байгаа нь тахир дутуу хүүхдэд гэр бүлийн зүгээс тавьж буй хандлагын ерөнхий байдлыг харуулж байна. Хүүхдүүдийн дөнгөж 1.3 хувь буюу 19 хүүхэд дээрх асуултад хангалтгүй, муу ханддаг гэж хариулсан байна. Ялангуяа хөдөлгөөний болон хараа, сонсгол, хэл ярианы гажигтай хүүхдүүдийн 81.3 хувь нь гэр бүлийн зүгээс тахир дутуу хүүхдэдээ тавих хандлага сайн гэж хариулсан байхад сэтгэцийн болон оюуны хомсдолтой хүүхдүүдийн 21.6-25.4 хувь нь 'дунд', 5.2-7.2 хувь нь 'тааруу' гэсэн хариулт өгсөн байгаагаас үзэхэд гэр бүлийн зүгээс ч өөрийнхөө тахир дутуу хүүхдүүдэд хандах хандлага янз бүр байна. (Хүснэгт 20).

Зураг 10.



Судлагдсан өрхийн 92.5 хувь нь тахир дутуу нэг хүүхэдтэй байхад 6 хувь нь тахир дутуу 2 хүүхэдтэй, 1 орчим хувь нь ийм 3 хүүхэдтэй өрх байна. Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын дүнгээр нийслэлийн боловсролгүй хүн амын 55.8 хувь нь 7-9 насны, 33.5 хувь нь 10-14 насны, 1.7 хувь нь 15-19 насны хүүхэд, залуучууд байна. 7-9 насны боловсролгүй хүн амын 20.7 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт, 19.2 хувь нь Баянзүрх, 17.3 хувь нь Баянгол дүүрэгт, 13.9 хувь нь Чингэлтэй дүүрэгт 9.4 хувь нь Хан-Уул дүүрэгт байна. Мөн 10-14 насны бага боловсролтой хүн амын 40 хувь нь Баянзүрх, Сонгино хайрхан дүүрэгт, 18.6 хувь нь Баянгол дүүрэгт, 13.4 хувь нь Чингэлтэй дүүрэгт, 12.2 хувь нь Сүхбаатар дүүрэгт 8.9 хувь нь Хан-Уул дүүрэгт



байна. Судалгаанд хамрагдсан тахир дутуу хүүхдүүдийн 21.8 хувь нь дээд боловсролтой тэргүүлэгчтэй өрхөд, 36.1 хувь нь бүрэн дунд боловсролтой тэргүүлэгчтэй, 34.7 хувь нь бүрэн бус дунд боловсролтой тэргүүлэгчтэй, 7.4 хувь нь боловсролгүй ба бага боловсролтой тэргүүлэгчтэй өрхөд тус тус хамаарч байна.

### II.7. Тахир дутуу болсон шалтгаан:


Хүүхдүүд тахир дутуу болж байгаагийн үндсэн шалтгааныг судлахад судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 30.5 хувь нь эм, хорт бодисоос, 24.3 хувь нь төрөхийн хүндрэлээс, 7.8 хувь нь удамшлын, 7.4 хувь нь халдварт өвчнөөс, 4.9 хувь нь ахуйн, 2.3 хувь нь автын ослоос, 0.1 хувь нь байгалийн гамшигаас тус тус шалтгаалж тахир дутуу байдалд хүрсэн байна. Түүнчлэн хоол, тэжээлийн дутагдал, сэтгэцийн өөрчлөлт, микроэлементийн дутагдлаас (10 хувь) шалтгаалсан байна. (Хүснэгт 21).

### II.8. Тахир дутуугийн хэлбэрүүд:

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн дунд хөдөлгөөний хомсдолтой 421 хүүхэд байгаагийн 54.4 хувь нь саажилттай, 5.5 хувь нь үе мөчний тайралттай, 4 хувь нь нуруу, нугасны гэмтэлтэй байна.

Оюуны хомсдолтой 366 хүүхдүүдийн 40.7 хувь нь дунд зэргийн, 31.7 хувь нь хүнд, 27.6 хувь нь хөнгөн зэргийн хомсдолтой байна. Харааны гажигтай, сул хараатай 183 хүүхдийн 52 нь харааны шил хэрэглэдэг байна.


Зураг 11.



Тахир дутуу хүүхдүүдийн амьдарч байгаа сууцны хэлбэрийг тэдний тахир дутуугийн хэлбэрээр нь ангилж үзэхэд сонсгол, хэл ярианы дутагдалтай хүүхдүүдийн 77 хувь, сэтгэцийн өөрчлөлттэй хүүхдүүдийн 72.2 хувь, хөдөлгөөний дутагдалтай


хүүхдүүдийн 71 хувь, оюуны хомсдолтой хүүхдүүдийн 68.9 хувь нь байшин сууцанд амьдарч байна.

Зураг 12.



Сонсгол, хэл ярианы гажигтай 395 хүүхдийн 33.9 хувь нь таг дүлий, 36.7 хувь нь сул сонсголтой, 20.1 хувь нь ярьдаггүй хүүхэд байна. Сонсгол хэл ярианы гажигтай хүүхдүүдийн тал хувь нь 9-15 насны хүүхдүүд байна. (Хүснэгт 22).


Зураг 13.



Судалгаанд үе мөчний тайралттай 19 хүүхэд хамрагдсаны 14 нь ослоос 4 нь төрөлхийн, нэг нь өвчнөөс болсон байна. Энэ хүүхдүүдийн 3 нь гар тайралттай байгаагийн 2 нь тохойноос доогуур, 1 нь тохойноос дээгүүр, 12 хүүхэд хөлний мөч тайралттай байгаагийн 8 нь өвдөгнөөс доогуур, 4 нь өвдөгнөөс дээгүүр, 4 хүүхдийн гар,хөлийн мөч нь хоёул тайралттай байна.


Мөчний тайралттай хүүхдүүдийн 17 нь эрэгтэй хүүхэд байгаагийн 10 хүүхэд нь ослоос шалтгаалж тайралт хийлгэсэн байгаа нь осолд эрэгтэй хүүхэд илүү өртөмтгий байдгийг харуулж байна. (Хүснэгт 23).

Зураг 14.



Харааны шил хэрэглэдэг хүүхдүүдийн 53.8 хувь нь эмэгтэй хүүхэд байгаагийн зэрэгцээ 55.8 хувь нь 9–15 насны хүүхдүүд, 7-8 болон 16-18 насны хүүхдүүд тус бүр 17.3 хувийг эзэлж байна. Харааны шил хэрэглэдэг хүүхдүүдийн 44.2 хувь нь Баянзүрх, 26.9 хувь нь Налайх дүүрэгт байна. (Хүснэгт 24).

Зураг 15.



## II.9. Тахир дутуу хүүхдийн эм тарианы хэрэглээ:

Судалгаанд хамрагдсан тахир дутуу нийт хүүхдүүдийн 19.8 хувь нь эм, тариа хэрэглэдэг байна. Тэдний 38.3 хувь нь амин дэм хэрэглэж байгаа нь зөвхөн Сонгинохайрхан дүүргийн хүүхдүүд байна. Энэ нь судалгааны мэдээлэл цуглуулагч нарын алдаа байж болох юм. Эм, тарианы хэрэглээний 67 хувийг зөвхөн 7-18 насны хүүхдүүд хэрэглэж байна. Эм тарианы ихэнхи хувийг тайвшруулах төрлийн зэрэг эм, тариа эзэлж байна.

## ГУРАВ. ТАХИР ДУТУУ ХҮҮХДИЙН ХЭРЭГЦЭЭ

### III.1. Тахир дутуу хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээний хэрэгцээ:

Судалгааны дүнгээс үзэхэд судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 54.3 хувь буюу 819 хүүхдэд дараахи нэрийн үйлчилгээнүүд шаардлагатай байна. Үүнд хүүхдүүдийн 32.8 хувьд нарийн мэргэжлийн эмч нарын үйлчилгээ, ялангуяа Багахангай (72.7 хувь), Багануур, Баянзүрх дүүргийн хүүхдүүдийн тус бүр 40 орчим хувьд хэрэгтэй байна. Хүүхдүүдийн 9.5 хувьд мэс заслын эмчилгээ, 42.5 хувьд сэргээн засах эмчилгээ, 2.4 хувьд нь гоо заслын эмчилгээ, шаардлагатай байна. Эдгээр тахир дутуу хүүхдүүдийн 9.4 хувь нь хөгжингүй улс оронд очиж эмчлүүлэх сонирхолтой байна. Сэргээн засах эмчилгээний дотроос хөдөлгөөний заслын эмчилгээний хэрэгцээ өндөр байна. (Хүснэгт 26).

### III.2. Шаардлагатай туслах тоног төхөөрөмжийн хэрэгцээ:

Судалгаанд хамрагдсан 864 хүүхдэд ямар нэг төрлийн туслах тоног төхөөрөмж хэрэгтэй гэсэн байна. Тэдний 23.7 хувьд нь сонсголын аппарат, 17.4 хувьд нь тэргэнцэр, 17.2 хувьд нь харааны шил, 13.8 хувьд нь таяг, тулгуурын хэрэгсэл, 12.3 хувьд нь хэл заслын хэрэгсэл, 3.6 хувьд нь хиймэл эрхтэн 10 орчим хувьд согог заслын хэрэгслүүд, тухайлбал 3.4 хувьд нь согог заслын гутал, 3.1 хувьд мөчний хамгаалалт, 2.4 хувьд нь нурууны бэхэлгээ хэрэгтэй байна. (Хүснэгт 27).

### III.3. Нийгмийн халамж, хамгааллын талаар:

Судалгаанд хамрагдсан тахир дутуу хүүхдүүдийн 22.5 хувь нь нийгмийн халамж, хамгаалалтад хамрагдсан байна. Тэдний 61.6 хувь нь байнгын тэтгэвэр, тэтгэмж авдаг, 17.3 хувь нь нэг удаагийн тусламж авсан, мөн ийм хэмжээний хүүхэд хөтөлбөр төсөлд хамрагдсан байна.

Харин 1156 хүүхэд нийгмийн халамжинд хамрагдаагүй байна. Зөвхөн Хан-Уул дүүргийн тахир дутуу хүүхдүүдийн 54.6 хувь нь нийгмийн халамж, хамгаалалтанд хамрагдсан нь дүүргүүдийн дунд хамгийн сайн нь байна. Ялангуяа Сонгинохайрхан, Багахангай, Баянгол, Багануур, Баянзүрх, Чингэлтэй дүүргүүдийн тахир дутуу хүүхдүүдийн 91.7-79.5 хувь нь нийгмийн халамж, хамгаалалтад хамрагдаагүй байна. (Хүснэгт 28).

Судалгаанд хамрагдсан тахир дутуу 1492 хүүхдийн 33,2 хувьд нь тэтгэлэг тэтгэмж тогтоож өгөх, 18.6 хувь нь рашаан, сувилалд сувилуулах, 16.5 хувь нь групп тогтоолгох,

11.2 хувь нь тусгай асрамж шаардлагатай гэсэн байна. Групп тогтоолгох хүсэлтэй хүүхдүүдийн 26.5-26.8 хувь нь оюуны болон сэтгэцийн хомсдолтой хүүхдүүд байна. Судалгааны дүнгээс үзэхэд харааны гажгаас бусад аль ч төрлийн гажиг, согогтой хүүхдүүдийн 1/3 орчим нь, харин харааны гажигтай 4 хүүхэд тутмын нэг нь тэтгэлэг тэтгэмж тогтоолгох хүсэлтэй байна. (Хүснэгт 29).

#### III.4. Онцгой хэрэгцээ

Тахир дутуу хүүхдүүдийн 87 хувьд нь ахуйн болон онцгой хэрэгцээ шаардлагатай байна. Тухайлбал энэ хүүхдүүдийн 36.6 хувьд нь материаллаг тусламж, 18.3 хувьд нь эмчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээ, 10.3 хувьд нь амьдрах дадал, хэвшилд суралцах, 6.3 хувь нь нийгэм олны дунд орох мөн тэдний 12.3 хувийнх эцэг, эхчүүдэд хүүхдээ хэрхэн асрах, талаар сургалт зөвлөлгөө авах шаардлага хэрэгцээ байна. Хүүхдүүдийн 3.9 хувь нь мэргэжлийн баримжаа олж авах талаар, 4 хувь нь боловсролтой болох талаар зөвлөгөө авах хүсэлтэй байна. Материаллаг дэмжлэг, туслалцаа авах хүсэлтэй хүүхдүүдийн 55-63 хувь нь Хан-Уул, Сүхбаатар дүүрэгт байна.

#### III.5. Авъяас сонирхол

Түүнчлэн 5-18 насны тахир дутуу хүүхдүүдийн авъяас сонирхолыг судлаж үзэхэд тэдний 21.1 хувь нь урлагийн, 16.6 хувь нь мужаан, дархан, гар урлалын, 13.2 хувь нь техникийн, 12.6 хувь нь цуглуулга хийх сонирхолтой байна. Харааны гажигтай хүүхдүүдийн 35.9 хувь нь урлагийн авъяастай, сонсгол хэл ярианы гажигтай хүүхдүүдийн 29 хувь нь мужаан, дархан, гар урлал сонирхдог гэж хариулснаас үндэслэн энэ насны хүүхдүүдэд зориулсан дээрхи чиглэлийн мэдлэг, баримжаа олгох хөтөлбөр, сургалтыг зохион байгуулах нь энэ хүүхдүүдийн ирээдүй, тэдний эрүүл мэнд, амьдралын хэрэгцээний нэгээхэн хэсгийг хөгжүүлэх боломжийг олгож болох юм. (Хүснэгт 31).

Судалгаанд хамрагдсан 10-18 насны хүүхдүүдийн бараг тал хувь нь ямар нэг хэлбэрийн ажил эрхэлж байгаа дүн гарав. Гэхдээ тахир дутуу хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг эргэн харах шаардлагатай байж болох юм. Судалгаагаар 13, 15-17 насны 413 хүүхэд ажил, хөдөлмөр эрхэлж байгаагийн 37.5 хувь нь хувийн байгууллага, 25 хувь нь төрийн байгууллагад, 12.5 хувь нь өрхийн аж ахуйд ажилладаг байна. Ажил, хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүд нь голдуу оюуны хомсдолтой, харааны согогтой, сонсгол, хэл ярианы гажигтай хүүхдүүд байна. (Хүснэгт 34).

Дээрхи насны хүүхдүүд инженер, зохион бүтээгч, зохиолч, хөгжимчин, дуучин, эмч зэрэг олон төрлийн мэргэжлийг сонгох хүсэлтэй байна. Тэдний 11.5 хувь нь багш, орчуулагч, 7.9 хувь нь засварчин, дархан, мужаан, 6.6 хувь нь жолооч, механик, 5.9 хувь нь оёдолчин болох сонирхолтой байна.

## ДҮГНЭЛТ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Тахир дутуу хүүхэд хаана, хэдий орчим байгааг илрүүлсний үндсэн дээр тахир дутуу хүүхдийн нэн шаардлагатай хэрэгцээг тодорхойлох энэ судалгааг явуулснаар тахир дутуу хүүхдүүдийн тахир дутуугийн хэлбэрийг тодруулж улмаар боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, хамгаалал, ахуйн болон онцгой хэрэгцээ, авьяас, сонирхлыг судлаж тахир дутуу хүүхдүүдийн байдлыг сайжруулах бодлого боловсруулах, энэ хүүхдүүдийн асуудлаар ажилладаг байгууллага, судлаач, хэрэглэгч нарт цаашид олон талын арга хэмжээ авахад үндэслэл болох мэдээллийг бүрдүүлж өгөв. Улаанбаатар хотын хэмжээнд тахир дутуу 0-18 насны хүүхдүүдийн нас, хүйс, тахир дутуугийн хэлбэр, амьдралын түвшинг харгалзан тэдний амьдарч, сурч боловсрох эрхийг хангах, олны дунд орж зэрэгцэн амьдарч, сурч боловсрох хүсэл мөрөөдлийг хэрэгжүүлэхийн тулд юуны өмнө

**нэгдүгээрт:** төрсөн эцэг, эх, ах, эгчийн асрамжинд байдаггүй хүүхдүүдийг нарийвчлан судлаж шалтгааныг тогтоосоны үндсэн дээр энэ хүүхдүүдийн талаар тусгай арга хэмжээ авах;

**хоёрдугаарт:** эрүүл мэндийн хувьд боломжтой хүүхдүүдэд сургуулийн өмнөх болон суурь боловсрол олгох арга хэмжээг санхүүгийн боломжтой уялдуулан зохион байгуулах. Тухайлбал: ердийн сургуульд эрүүл хүүхдүүдтэй хамт сургах, сургуульд эрүүл мэндийн байдал хүндрэлтэй хүүхдүүдэд зориулсан албан бус сургалтыг, өсвөр насны охид, хөвгүүдэд тусгай хэрэгцээт боловсрол олгох арга хэмжээг зохион байгуулах;

**гурвдугаарт:** нөхөн сэргээх эмчилгээ, нарийн мэргэжлийн эмч нарын зөвлөлгөө, хяналтанд байнга хамруулах, нарийн мэргэжлийн эмч нарын зөвлөмжөөр шинээр эмчилгээнд нэвтрүүлж байгаа зөвшөөрөгдсөн сайн чанарын эм, тариагаар, боломжит түвшний үнээр хангах арга хэмжээг авах, мөн шаардлагатай тоног төхөөрөмж, гоо заслын эмчилгээ, үйлчилгээгээр хангах асуудлыг шийдэх, гадаадын хүмүүнлэгийн байгууллагуудын дэмжлэгийг авах;

**дөрөвдүгээрт:** орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад ажиллаж байгаа хүүхдийн болон нийгмийн ажилтны хариуцлагыг өндөржүүлж нийгмийн халамж, хамгаалалтад хамрагдаагүй дээрхи хүүхдүүдийн асуудлыг яаралтай шийдүүлэх,

**тавдугаарт:** ахуйн болон онцгой хэрэгцээ шаардлагатай хүүхдүүдийг орон нутгийн байгууллагатай хамтран нарийвчлан тодруулж асуудлыг шийдэх,

**зургаадугаарт:** энэ судалгаагаар хүүхдүүд тахир дутуу болж байгаа үндсэн шалтгаануудыг илрүүлсний мөрөөр ахуйн болон автын ослоос сэрэмжлүүлэх арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан сурталчлах, үндсэн шалтгаануудын 50 гаруй хувь нь төрөхийн хүндрэл, эм, хорт бодсисын хэрэглээ эзэлж байгааг онцгой

анхаарч, мэргэжлийн байгууллага, эмч нарын мэдлэг, дадлага, хяналтыг дээшлүүлэхэд анхаарч цаашид гарч болзошгүй шалтгаан, нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг өргөн олон нийтийг хамруулан авах шаардлагатай. Тахир, дутуу болоход нөлөөлж байгаа төрөхийн хүндрэл, эм, хорт бодис, халдварт өвчний үүсэл, нөхцөл, нөлөөллийг нарийн судлах нь чухал юм.

Судалгааны дүнгээс үзэхэд хотын төвөөс алслагдсан, гэр хороолол зонхилсон хүн амын нягтрал ихтэй газрууд тухайлбал Сонгино хайрхан, Баянзүрх, Баянгол дүүргүүдэд тахир дутуу хүүхэд олон байгаа нь тэнд тахир дутуу хүүхдүүдийн нийгмийн халамж, хамгаалал, боловсрол, сургалт, эрүүл мэндийн үйлчилгээний асуудлыг иж бүрнээр шийдэх шаардлагатай байгааг харуулж байна. Түүнчлэн тахир дутуу хүүхдүүд болон тэдний ар гэрийнхэнд нь нийгмийн халамжийн болон бусад холбогдох хууль тогтоомжийг танилцуулах, сурталчлах, асаргаа сувилгаанд сургах, мэргэжлийн баримжаа олгох болон нарийн мэргэжлийн эмч нарын зөвлөлгөө өгөх төвийг нийслэл, дүүргийн хэмжээнд байгуулж, ажиллуулах. Мөн тахир дутуу хүүхдүүдтэй ажилладаг Төрийн болон Төрийн Бус Байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна.



Хавсралт 1

**ТАХИР ДУТУУ ХҮҮХДИЙН ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ  
СУДАЛГААНЫ АСУУЛГЫН МАЯГТЫГ НӨХӨХ ЗААВАР**

**Судалгааны зорилго:**

- Тахир дутуу хүүхдийн тоог нас, хүйсээр тодорхойлох.
- Тахир дутуу хүүхдийн амьдарч байгаа нөхцөл, орчинг судлах
- Тэдгээрийн тахир дутуугийн хэлбэрийг тодорхойлох
- Тахир дутуу хүүхдүүдийн хүсэл, хэрэгцээг судлах явдал юм.

**Судалгааны хамралт:**

Судалгаанд 18 хүртэлх насны, тахир дутуу хүүхэдтэй өрхүүд хамаарна.

**Судалгааны асуулгыг авах арга:**

Энэхүү судалгааг өрхийн эмч нарын тусламжтайгаар баг, хорооны нийгмийн ажилтан нартай хамтран явуулна. Ярилцлага авагч нар нь судалгаанд хамрагдвал зохих өрхүүдээр явж асуулгын маягтын дагуу ярилцлагыг явуулж судалгааг авна.

**Судалгааны асуулга:**

Энэхүү асуулгын маягт нь 4 бүлгээс бүрдэнэ. Үүнд:

- А. Хаягийн хэсэг
- Б. Өрхийн ам бүл, боловсрол, ажил эрхлэлт
- В. Тахир дутуу хүүхдийн талаар
- Г. Тахир дутуу хүүхдийн хэрэгцээ

Асуулгын бүлэг бүр нь тодорхой тооны асуулга, дэд бүлэгтэй байна.

- Хаягийн хэсэг: - 15 асуулт.
- Өрхийн ам бүл, гишүүдийн боловсрол, ажил эрхлэлт: 3 дэд бүлэг, нийт 13 асуулттай
- Тахир дутуу хүүхдийн талаар: 19 асуулттай.
- Тахир дутуу хүүхдийн хэрэгцээ: 5 дэд бүлэг 16 асуулттай байна.

Судалгааны асуулгыг нөхөхөд тухайн асуулгын хариултанд ашиглах боломжит хариултын дагуу өгөгдсөн шифр, кодыг ашиглах нь асуулгын явц, боловсруулалтын байдлыг хөнгөвчлөх болно. Иймээс асуулт бүрийн хариултыг тодорхой шифрээр нөхөн бичнэ, гэхдээ зарим тохиолдолд тодруулж үсгээр бичих шаардлагатай болохыг анхаар.

Асуултыг 'Дармал үсгээр', тухайн асуултын боломжит хариултуудыг 'бичмэл үсгээр' арай бага фондоор бичсэн болно.

Асуулт бүрт холбогдох хариултуудын аль нэгийг заавал нөхөж бичсэн байх хэрэгтэй. Зарим асуултын хариултаас хамаарч дараагийн асуултыг алгасч болох ба энэ тохиолдолд аль асуултыг асуухыг шаардлагатай хариултын ард сумаар зааж өгсөн байгаа. Жишээ нь: 'Тийм-1 А19' гэсэн нь асуулт 19 рүү оч гэсэн утга болно.

## **А. Хаягийн хэсэг:**

**Асуулт 1-3:** Судалгаа авч байгаа өрхийн харьяалж байгаа аймаг, хот, сум, дүүрэг, багийн нэрийг холбогдох мөрөнд бичиж, хамаарах кодыг өгөгдсөн нүдэнд бичнэ.

**Асуулт 4. Өрхийн байршил:** Судалгаанд хамрагдаж байгаа өрх нь нийслэл хот, аймгийн төв, сумын төв, хөдөөгийн хаана нь хамаарч байгаагаас хамаарч өгөгдсөн кодын аль тохирохыг бич. Үүнд : нийслэл хотын өрх бол-1. Аймгийн төвийн өрх -2. Сумын төвд байдаг бол -3. Хөдөөгийн өрх бол-4 гэсэн кодыг хэрэглэ.

### **Асуулт 5. Өрхийн дугаар:**

Өрхийн дугаарыг судалгааны ажлын төв бүлгээс өгнө. Өгөгдсөн дугаарыг холбогдох нүдэнд бичнэ.

**Асуулт 6. Тухайн өрхийн ам бүлийн тоог бичнэ.** Ам бүлийн тоонд тухайн 6 сараас доошгүй хугацаагаар гадагш явсан буюу байхгүй байгаа энэ өрхийн гишүүдийг хамруулахгүй, Гэхдээ сургуульд суралцахаар явж 9 сар хүртэл хугацаагаар түр эзгүй байгаа гишүүдийг өрхийн ам бүлийн тоонд хамааруулна.

**Асуулт 7.** Судалгаанд хамрагдаж байгаа өрхөд 18 хүртэлх насны хэдэн хүүхэд байгааг асууж бичнэ.

**Асуулт 8-9.** Дээрхи 18 хүртэлх насны хүүхдээс хэд нь тахир дутуу хүүхэд вэ мөн энэхүү тахир дутуу хүүхдүүдээс хэд нь судалгаанд хамрагдсаныг тодруулж, тоог бичнэ.

**Асуулт 10.** Өрхийн сууцны байдлыг тодорхойлно. Үүнд: *Байшин сууц:* өвөл, зуны аль ч улиралд амьдарч болох байшин сууцнууд хамаарна. жишээ нь: улсын болон амины орон сууц, нийтийн байрнууд, нийтийн эзэмшлийн бусад байр хамаарна. Байшин сууц болон гэрт хамаарахгүй, гэхдээ хүн амьдарч байгаа сууцны болон сууцны бус зориулалтын оромжуудыг бусдад хамааруулна.

**Асуулт 11.** Сууцны өмчийн хэлбэр: Байшин сууц, гэр байрыг өмчийнх нь харьяаллаар улсын / төрийн / , хувийн , холимог гэж 3 ангилна. Үүнд: *Төрийн:* Төрийн болон төрийн өмч давамгайлсан (төрийн өмч нь 51 хувиас дээш) аж ахуйн нэгж, байгууллагын мэдлийн сууц (сууж байгаа өрх сууцаа өмчилж аваагүй), гэр байрыг үүнд хамааруулна. *Хувийн:* Хүмүүс өөрөө барьсан хувийн орон сууц миён хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын (өмчийнх нь 51 хувиас дээш хувийн өмчтэй) мэдлийн сууц, гэр энд хамаарна. *Холимог:* Төрийн хувийн өмч холимог (адилхан 50 хувийн өмчтэй) мэдлийн сууц, гэр энд хамаарна.

**Асуулт 12.** Сууц эзэмшлийн байдал: Тухайн сууцыг эзэмших эрхийн бичигтэй (байшин сууцны хувьд) эсэхийг асууна. Энэ асуултаар тухайн өрх сууцны өмчийн хэлбэрээс үл хамаарч өөрсдийн сууцандаа амьдарч байгаа эсэхийг тодруулна. Жишээлбэл: бусдын гэрийг түрээслэж байгаа эсвэл айлын илүү буюу хажуу өрөөг хөлсөлж суугаа г.м.

